



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/119

Арвайхээр сум

Нутгийн захиргааны байгууллагын 2022 оны  
үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ,  
үнэлгээний дүнгийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.11.а, 9.11.б, 9.12, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нутгийн захиргааны байгууллагын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тэргүүлсэн Хужирт, Хайрхандулаан, Арвайхээр, Бат-Өлзий, Уянга сумдыг тус бүр 3,000,000 (гурван сая) төгрөг, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрыг тус бүр 2,000,000 (хоёр сая) төгрөгөөр шагнасугай.

2.Шагналын зардалд шаардагдах 21,000,000 (хорин нэгэн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3.Үйл ажиллагааны дүнгээр тэргүүлсэн Хужирт, Хайрхандулаан, Арвайхээр, Бат-Өлзий, Уянга сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын дарга нарт, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга нарт тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс олгохыг нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0114